

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч

АГУУЛГА

1. Төрийн аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал.....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН
ЗАХИРАЛ Н.ОЮУНТЭГШ ТАНАА

2021.02.24 № 07/469
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол төрийн түүхийн музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол төрийн түүхийн музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76,962,008.94	83,697,621.25
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	977,502.00	475,640.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	977,502.00	475,640.00
31110	Төгрөг	977,502.00	475,640.00
33	АВЛАГА	6,264,711.94	7,445,721.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	67,311.94	-
335	Бусад авлага	6,197,400.00	7,445,721.00
3351	Байгууллагаас авах авлага	6,197,400.00	7,445,721.00
34	УРЬДЧИЛГАА	8,254,868.00	21,636,965.57
34200	Төсөвт байгууллага	8,254,868.00	21,636,965.57
35	БАРАА МАТЕРИАЛ	61,464,927.00	54,139,294.68
354	Хангамжийн материал	61,464,927.00	54,139,294.68
35410	Бичиг хэргийн материал	6,608,069.00	5,886,492.00
35420	Аж ахуйн материал	38,750,915.00	30,847,415.68
35430	Сэлбэг хэрэгсэл	2,767,390.00	3,688,470.00
35440	Түлш, шатах тослох материал	109,575.00	109,575.00
35470	Бусад хангамжийн материал	13,228,978.00	13,607,342.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	512,722,728.18	520,037,560.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	512,722,728.18	520,037,560.12
392	Биет хөрөнгө	512,667,279.53	520,037,560.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,500,000.00	6,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,500,000.00)	(6,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	51,065,224.75	62,695,224.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,654,458.62)	(44,594,669.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,174,560.00	68,174,560.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,776,996.64)	(67,650,980.22)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	484,716,160.80	484,716,160.80
39214	Бусад үндсэн хөрөнгө	136,002,807.30	140,787,507.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	(130,614,114.06)	(132,844,339.00)
39217	Ном	8,754,096.00	8,754,096.00
393	Биет бус хөрөнгө	55,448.65	-
39301	Програм хангамж	41,776,640.00	41,776,640.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(41,721,191.35)	(41,776,640.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	589,684,737.12	603,735,181.37
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	589,684,737.12	603,735,181.37
51	Засгийн газрын хувь оролцоо	589,684,737.12	603,735,181.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	742,060,566.40	742,060,566.40
51101	Өмч: - төрийн	742,060,566.40	742,060,566.40
512	Хуримтлагдсан үр дүн	(156,652,095.68)	(142,601,651.43)
51210	Өмнөх үеийн үр дүн	(148,751,493.19)	(156,652,095.68)
51220	Тайлант үеийн үр дүн	(7,900,602.49)	14,050,444.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,276,266.40	4,276,266.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	589,684,737.12	603,735,181.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	242,346,750.00	313,492,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,441,550.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,441,550.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,441,550.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,441,550.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	240,905,200.00	313,492,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	240,905,200.00	313,492,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	240,905,200.00	313,492,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	250,247,352.49	299,441,655.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	250,247,352.49	299,441,655.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	240,144,879.30	269,787,457.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168,029,294.99	195,106,407.65
210101	Үндсэн цалин	168,029,294.99	195,106,407.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,953,036.25	24,364,841.77
210201	Тэтгэврийн даатгал	20,953,036.25	24,364,841.77
2104	Хангамж, бараа материалын зардал	16,579,124.50	24,335,059.94
210401	Бичиг хэрэг	2,168,208.00	2,540,977.00
210402	Тээвэр шатахуун	5,855,261.00	9,164,139.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	393,105.50	938,466.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,571,750.00	1,990,000.00
210408	Бараа материал акталсны зардал	2,590,800.00	9,701,477.32
2107	Томилолт, зочны зардал	795,000.00	-
210702	Дотоод албан томилолт	795,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,899,868.00	14,172,470.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	459,968.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	11,880,000.00	12,127,602.43
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	559,900.00	1,044,868.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,888,555.56	11,808,678.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,274,550.00	2,708,810.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	13,614,005.56	9,099,868.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,102,473.19	29,654,197.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,102,473.19	27,654,197.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,102,473.19	27,654,197.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(7,900,602.49)	14,050,444.25
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(7,900,602.49)	14,050,444.25

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	240,905,200.00	313,492,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	240,905,200.00	313,492,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	240,905,200.00	313,492,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	240,905,200.00	313,492,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	233,391,800.00	297,579,262.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	233,391,800.00	297,579,262.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	223,289,326.81	267,925,064.10
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	166,531,037.31	194,708,927.17
210101	Үндсэн цалин	132,724,137.31	138,898,725.17
210102	Нэмэгдэл	17,940,000.00	44,108,394.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	15,866,900.00	11,701,808.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,408,700.00	24,523,180.31
210201	Тэтгэврийн даатгал	21,408,700.00	24,523,180.31
2104	Хангамж, бараа материалын зардал	6,189,331.50	13,960,626.62
210401	Бичиг хэрэг	813,700.00	1,020,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,344,476.00	10,412,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	433,005.50	1,328,166.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	598,150.00	1,200,000.00
2105	Нормативт зардал	2,430,000.00	2,420,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,430,000.00	2,420,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,663,090.00	14,915,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,729,600.00	1,795,600.00
210604	Урсгал засвар	3,933,490.00	13,120,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,199,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,199,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,411,568.00	14,574,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	511,700.00	990,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	11,880,000.00	12,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,019,868.00	584,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,456,600.00	2,821,830.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,456,600.00	2,821,830.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,102,473.19	29,654,197.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,102,473.19	27,654,197.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,102,473.19	27,654,197.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,513,400.00	15,912,838.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,513,400.00	16,414,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,513,400.00	16,414,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,513,400.00	16,414,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,513,400.00	16,414,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(7,513,400.00)	(16,414,700.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(501,862.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	977,502.00	977,502.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	977,502.00	475,640.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	742,060,566.40	4,276,266.40	(148,751,493.19)	597,585,339.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(7,900,602.49)	(7,900,602.49)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	742,060,566.40	4,276,266.40	(156,652,095.68)	589,684,737.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	14,050,444.25	14,050,444.25
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	742,060,566.40	4,276,266.40	(142,601,651.43)	603,735,181.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	977,502.00	977,502.00	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	313,492,100.00	286,339,764.10	(27,152,335.90)	91.3
УРСГАЛ ЗАРДАЛ	313,492,100.00	286,339,764.10	(27,152,335.90)	91.3
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	311,492,100.00	284,339,764.10	(27,152,335.90)	91.3
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	210,552,400.00	194,708,927.17	(15,843,472.83)	92.5
Үндсэн цалин	149,831,400.00	138,898,725.17	(10,932,674.83)	92.7
Нэмэгдэл цалин	44,854,100.00	44,108,394.00	(745,706.00)	98.3
Унаа хоолны Хөнгөлөлт	15,866,900.00	11,701,808.00	(4,165,092.00)	73.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,424,600.00	24,523,180.31	(3,901,419.69)	86.3
Тэтгэврийн даатгал	28,424,600.00	24,523,180.31	(3,901,419.69)	86.3
Хангамж, бараа материалын зардал	14,463,700.00	13,960,626.62	(503,073.38)	96.5
Бичиг хэрэг	1,030,000.00	1,020,000.00	(10,000.00)	99.0
Тээвэр, шатахуун	10,413,700.00	10,412,460.00	(1,240.00)	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,336,000.00	1,328,166.62	(7,833.38)	99.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	484,000.00	-	(484,000.00)	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
Нормативт зардал	2,435,400.00	2,420,000.00	(15,400.00)	99.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,435,400.00	2,420,000.00	(15,400.00)	99.4
Эд хогшил, урсгал засварын зардал	31,937,000.00	31,330,300.00	(606,700.00)	98.1
Багаж, техник, хэрэгсэл	18,600,000.00	18,210,300.00	(389,700.00)	97.9
Урсгал засвар	13,337,000.00	13,120,000.00	(217,000.00)	98.4
Томилолт, зочны зардал	1,199,000.00	-	(1,199,000.00)	-
Дотоод албан томилолт	1,199,000.00	-	(1,199,000.00)	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,580,000.00	14,574,900.00	(5,100.00)	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	990,000.00	990,000.00	-	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	12,000,000.00	12,000,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	-	-	-	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	590,000.00	584,900.00	(5,100.00)	99.1
Бараа үйлчилгээний бусад зардал	7,900,000.00	2,821,830.00	(5,078,170.00)	35.7
Бараа үйлчилгээний бусад зардал	2,900,000.00	2,821,830.00	(78,170.00)	97.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	5,000,000.00	-	(5,000,000.00)	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	-	100.0

Монгол төрийн түүхийн музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	313,492,100.00	285,837,902.10	(27,654,197.90)	91.2
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	313,492,100.00	285,837,902.10	(27,654,197.90)	91.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	475,640.00	475,640.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
Төсвийн байгууллага	1	1	-	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	14	-	77.8
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	11	7	-	63.6
Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол төрийн түүхийн музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Н.Оюунтэгш танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 13-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Баян суварга Аудит” ХХК-ийн Захирал С.Должинсүрэн хянан удирдаж, чанарын хяналт хэрэгжүүлэх, чанарын менежер Г.Мөнхзул, ахлах аудитор Г.Юра, гэрээт аудитор Ч.Эрдэнэчимэг, аудиторын туслах Т.Бөртэ-үжин нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол төрийн түүхийн музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Х/58 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Монгол төрийн түүхийн музейн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн түүхэнд холбогдох дурсгалыг цуглуулж, хадгалан хамгаалах, судлан шинжлэх, ирээдүйн хойчдоо өвлүүлэн үлдээх, Монгол төрийн түүхэн хөгжил, залгамж шинжийг сурталчлан, нийгмийн ухамсарт нөлөөлж төлөвшүүлэх” гэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн түүхтэй холбоотой түүх соёлын дурсгалт зүйлсийг цуглуулах, хадгалах, хамгаалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, сурталчлах үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-ын 9 дүгээр хавсралт *“Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”*
- Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол *“Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол *“Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”*

- Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”
- Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай”
- Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Монгол төрийн түүхийн музей санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монгол төрийн түүхийн музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг үндэслэн 250,247.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,004.9 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол төрийн түүхийн музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,050.5 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө (касс дахь бэлэн мөнгө)	977.5	475.6	(501.9)
Авлага	6,264.7	7,445.7	1,181.0
Урьдчилгаа	8,254.9	21,637.0	13,382.1
Бараа материал	61,464.9	54,139.3	(7,325.6)
Үндсэн хөрөнгө	512,722.7	520,037.6	7,314.9
Нийт хөрөнгө	589,684.7	603,735.2	14,050.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч	589,684.7	603,735.2	14,050.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	589,684.7	603,735.2	14,050.5

Авлага дансны үлдэгдэл 7,445.7 мянган төгрөг болж, 1.181.0 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын автобаазын нэхэмжлэлийн дагуу шилжүүлснээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2007 онд үүссэн, найдваргүй болсон эрсдэлтэй 6,197.4 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна. Энэ нь музейн ашиглалтын өмнөх захиргааны сонгон шалгаруулалтаар шалгарсан “Оргилсофт” ХХК техник хэрэгслээ дутуу нийлүүлсний улмаас үүссэн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 21,637.0 мянган төгрөг болж, 13,382.1 мянган төгрөгөөр өссөн шалтгааныг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

Харилцагч байгууллагын нэр	Дүн	Тайлбар
“Хаан даатгал” ХХК	7,627.4	Музейн үзмэрийн даатгалын урьдчилгаа
“Жинст нөмрө”г ХХК	7,120.0	Засварын ажлын урьдчилгаа
“Наран орд” ХХК	6,000.0	Засварын ажлын урьдчилгаа
“Интерактив Би Ай” ХХК	460.0	Санхүүгийн програмын лиценз ашиглалтын төлбөр
“Түгээмэл шуурхай шуудан” ХХК	429.6	2021 оны хэвлэл захиалгын төлбөр
Нийт дүн	21,637.0	

Бараа материалын дансны үлдэгдэл 54,139.3 мянган төгрөг болж өмнөх оноос 7,325.6 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалын нөөцөд байсан үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 520,037.6 мянган төгрөг болж 7,314.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 11,630.0 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдаж авсан нь шалтгаалжээ.

Монгол төрийн түүхийн музейн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 71,145.3 мянган төгрөгөөр буюу 29.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан улсын төсвөөс санхүүжих хөрөнгийн санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал төлөвлөснөөс 28,652.3 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн цалин, нэмэгдэл цалингийн зардлууд байна. Энэ нь батлагдсан орон тооноос 4 хүнээр дутуу буюу музейн сан хөмрөгчийг хавсран ажиллуулснаас шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2020 оны төсвийн төслийг 612,807.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 371,902.5 мянган төгрөгөөр бууруулж 240,905.2 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2020 оны төсвийн тодотголоор нийт 74,086.9 мянган төгрөг (үүнд:-цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 39,283.1.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 7,015.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 10,183.8 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 20,766.1 мянган төгрөг)-өөр нэмэгдүүлж, 314,992.1 мянган төгрөгөөр

баталсан байна. Энэ нь төсвийн төлөвлөлтийг үндэслэлгүйгээр хэт өндөр дүнгээр төлөвлөж байгааг харуулж байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 314,992.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 285,837.9 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр авч, 501.9 мянган төгрөгийг оны эхний мөнгөн хөрөнгийн үлэгдлээс зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 286,339.8 мянган төгрөг буюу 90.9 хувиар төсвийг зарцуулж, үлдэгдэл 27,654.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 168 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, хугацаа хоцроосон 29 мэдээлэл байна. 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тайланг мэдээлээгүй, мөн цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого санхүүжилтийн 14, зарлагын 2 гүйлгээний нийт 339,247.2 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,524.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 50.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	2	6,524.4	1	327.0	1	6,197.4	50.0
Нийт дүн	2	6,524.4	1	327.0		6,197.4	50.0

Хэрэгжүүлээгүй 6,197.4 мянган төгрөгийн 1 зөвлөмжид албан шаардлага тогтоож хүргүүлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 22,398.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9,701.5 мянган төгрөгийн алдааг залруулж 6,500.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд бараа материалын зардалд 9,701.5 мянган төгрөгийг тайлагнасан боловч бараа материалын тодруулга тайланд акталж зарлага болгосон хөрөнгөөр тайлагнаагүй байсныг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 12,697.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 6,197.4 мянган төгрөгийн зөрчилд болон Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2007 онд музейн ашиглалтын өмнөх захиргааны сонгон шалгаруулалтаар шалгарсан Оргилсофт ХХК техник хэрэгслээ дутуу нийлүүлсний улмаас үүссэн 6,197.4 мянган төгрөгийн найдваргүй авлагыг удирдах дээд байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “оршин байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.12-т *“Найдваргүй авлагыг бүртгэхдээ авлагыг хорогдуулах хэмжээ, баримтлах зарчим, нөхцлийг заасан эрх бүхий байгууллагын найдваргүй болсон авлагыг данснаас хасах тухай шийдвэрийг үндэслэнэ”* гэж заасны дагуу уг асуудлыг дээд шатны байгууллагадаа хандаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.

2. Дээр дурдсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,

3. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол төрийн түүхийн музейн удирдлагад даалгав.

2. Монгол төрийн түүхийн музейн шилэн дансны 2020 оны мэдээллийг харилцах дансны гүйлгээ болон мөнгөн хөрөнгийн журналын бичилттэй тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын нийт 16 гүйлгээний мэдээллийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.9-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол төрийн түүхийн музейн удирдлагад даалгав.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 6,500.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Монгол төрийн түүхийн музейд дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Төрийн өмчийн хорооны 2008 оны 549 дүгээр тогтоолоор ЗГХЭГ-ын эзэмшилд байсан 1995 онд үйлдвэрлэгдсэн 6,500.0 мянган төгрөгийн анхны өртөг бүхий Мицубиши маркын Делика бага оврын автобусыг тус музейд балансаас балансад шилжүүлэн өгсөн байна.

Уг автомашин нь ашиглах хугацаа дуусч, үндсэн эд ангиудын эвдрэл, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсны улмаас 2018 оноос хойш ашиглагдаагүй, үндсэн хөрөнгийн дансанд үлдэгдлээр бүртгэгдэж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-д “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “оршин байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд хөрөнгийн дүн буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд буруу мэдээлэл өгөх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын Автобаазын удирдлагатай зөвшилцөн автын мэргэжлийн хүмүүсийн оролцоотойгоор Техникийн комиссын акт тогтоолгож, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргуулж, холбогдох баримтуудыг бүрдүүлэн ТӨБЗГ-т актлах санал хүргүүлж шийдвэрлүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Монгол төрийн түүхийн музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/301/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол төрийн түүхийн музей		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2007 онд музейн ашиглалтын өмнөх захиргааны сонгон шалгаруулалтаар шалгарсан Оргилсофт ХХК техник хэрэгслээ дутуу нийлүүлсний улмаас үүссэн 6,197.4 мянган төгрөгийн найдваргүй авлагыг удирдах дээд байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэхээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	6,197.4	Албан шаардлага	Музейн захирал Ерөнхий нягтлан бодогч	Н.Оюунтэгш Д.Цэцэгмаа
2	Монгол төрийн түүхийн музейн шилэн дансны 2020 оны мэдээллийг харилцах дансны гүйлгээ болон мөнгөн хөрөнгийн журналын бичилттэй тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын нийт 16 гүйлгээний мэдээллийг оруулаагүй байна.	-	Албан шаардлага	Музейн захирал Ерөнхий нягтлан бодогч	Н.Оюунтэгш Д.Цэцэгмаа
3	Төрийн өмчийн хорооны 2008 оны 549 дүгээр тогтоолоор ЗГХЭГ-ын эзэмшилд байсан 1995 онд үйлдвэрлэгдсэн 6,500.0 мянган төгрөгийн анхны өртөг бүхий Мицубиши маркын Делика бага оврын автобусыг тус музейд балансаас балансад шилжүүлэн өгсөн байна. Уг автомашин нь ашиглах хугацаа дуусч, үндсэн эд ангиудын эвдрэл, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсны улмаас 2018 оноос хойш ашиглагдаагүй, үндсэн хөрөнгийн дансанд үлдэгдлээр бүртгэгдэж байна.	6,500.0	Зөвлөмж	Музейн захирал Ерөнхий нягтлан бодогч	Н.Оюунтэгш Д.Цэцэгмаа
ДҮН		12,697.4			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 24

№ 12/A0160056

Улаанбаатар хот

САГ- 2021/301/СТА-тшз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол төрийн түүхийн музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус музейн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2007 онд музейн ашиглалтын өмнөх захиргааны сонгон шалгаруулалтаар шалгарсан "Оргилсофт" ХХК нь техник хэрэгслээ дутуу нийлүүлсний улмаас үүссэн 6,197.4 мянган төгрөгийн найдваргүй авлагыг удирдах дээд байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэхээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлагналын "оршин байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол төрийн түүхийн музейн захирал Н.Оюунтэгш, Ерөнхий нягтлан бодогч Д.Цэцэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
"БАЯН СУВАРГА АУДИТ" ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ДАВААДОРЖ

Г.ЮРА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2021\0224auditin 2-R Gazar2.Docx

001080997



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 24

№ 13/АД160056

Улаанбаатар хот

САН- 2021/301/СТД-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол төрийн түүхийн музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус музейн шилэн дансны 2020 оны мэдээллийг харилцах дансны гүйлгээ болон мөнгөн хөрөнгийн журналын бичилттэй тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын нийт 16 гүйлгээний мэдээллийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.9-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол төрийн түүхийн музейн захирал Н.Оюунтэгш, ерөнхий нягтлан бодогч Д.Цэцэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
"БАЯН СУВАРГА АУДИТ" ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ДАВААДОРЖ

Г.ЮРА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0224auditin 2-R Газар5.Docx

001081009

[illegible]

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.